

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/38/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Төлбөрийн акт	15
4.2 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/111

БУУЦАГААН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.БОЛОРМАА

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ



**Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>125,599,092.29</u>	<u>131,137,725.29</u>
33	АВЛАГА	11,995,000.00	2,328,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,110,000.00	1,960,000.00
335	Бусад авлага	9,885,000.00	368,400.00
3351	Байгууллагаас авах авлага	9,885,000.00	368,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	113,604,092.29	128,809,325.29
351	Түүхий эд материал	7,434,500.00	9,220,498.00
35110	Тусгай зориулалттай материал	5,198,000.00	6,932,368.00
35130	Эм боох материал	2,236,500.00	2,288,130.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	1,129,710.00
354	Хангамжийн материал	106,169,592.29	118,459,117.29
35410	Бичиг хэргийн материал	2,566,120.00	2,910,000.00
35420	Аж ахуйн материал	40,868,549.00	41,576,549.00
35460	Хүнсний материал	00.00	2,549,990.00
35470	Бусад хангамжийн материал	62,734,923.29	71,422,578.29
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,448,318,665.32</u>	<u>6,292,236,846.48</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,448,318,665.32	6,292,236,846.48
392	Биет хөрөнгө	6,372,623,040.32	6,216,836,846.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,405,928,891.17	6,405,928,891.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-426,056,292.84	-639,712,067.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	192,112,658.36	263,601,158.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-165,986,185.68	-175,563,361.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,585,836.06	110,580,836.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,064,726.15	-86,672,348.86
39216	Дуусаагүй барилга, байгууламж	301,816,000.00	301,816,000.00
39217	Ном	36,286,859.40	36,857,739.40
393	Биет бус хөрөнгө	75,695,625.00	75,400,000.00
39301	Програм хангамж	3,641,200.00	3,641,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,345,575.00	-3,641,200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	75,400,000.00	75,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,573,917,757.61</u>	<u>6,423,374,571.77</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>22,102,489.00</u>	<u>87,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,102,489.00	87,000.00
413	Өглөг	22,102,489.00	87,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	22,102,489.00	87,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,551,815,268.61</u>	<u>6,423,287,571.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,551,815,268.61	6,423,287,571.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	763,215,984.63	763,215,984.63
51101	Өмч: - төрийн	763,215,984.63	763,215,984.63
512	Хуримтлагдсан үр дүн	3,659,336,274.44	3,530,808,577.60
51210	Өмнөх үеийн үр дүн	3,659,336,274.44	3,659,336,274.44
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-128,527,696.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,129,263,009.54	2,129,263,009.54

**Буцаагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,573,917,757.61	6,423,374,571.77
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,304,987,863.91	1,453,730,723.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,243,413.91	35,810,453.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,243,413.91	35,810,453.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,243,413.91	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,243,413.91	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	00.00	28,944,360.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-бараа материал	00.00	6,866,073.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,299,744,450.00	1,417,920,270.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,054,586,900.00	1,041,709,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,054,586,900.00	1,041,709,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,150,950.00	53,209,881.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,150,950.00	53,209,881.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	212,006,600.00	323,001,189.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	212,006,600.00	323,001,189.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,508,294,340.16	1,582,258,419.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,438,391,567.16	1,490,247,365.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,438,391,567.16	1,490,247,365.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	784,049,677.00	776,645,903.00
210101	Үндсэн цалин	432,138,437.00	602,980,002.00
210102	Нэмэгдэл	251,453,183.00	125,594,601.00
210104	Урамшуулал	100,458,057.00	48,071,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,420,383.00	101,084,421.83
210201	Тэтгэврийн даатгал	68,724,868.00	70,625,113.73
210202	Тэтгэмжийн даатгал	7,235,393.00	7,876,506.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,331,275.00	6,234,005.23
210204	Ажилгүйдлийн даатгал	1,536,439.00	1,485,091.77
210205	Эрүүл мэндийн даатгал	15,592,408.00	14,863,704.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,269,649.00	299,922,700.00
210301	Гэрэл, цахилгаан	8,313,189.00	8,424,000.00
210302	Түлш, халаалт	219,708,560.00	282,498,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,247,900.00	9,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,335,908.07	9,641,671.00
210401	Бичиг хэрэг	1,729,250.00	1,708,611.00
210402	Тээвэр, шатахуун	5,872,090.00	2,555,455.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,515,500.00	2,258,300.00
210404	Ном, хэвлэл	237,500.00	165,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,057,300.00	374,945.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	682,600.00	2,579,360.00
210408	Бараа материал акталсны зардал	26,241,668.07	00.00
2105	Нормативт зардал	42,401,655.00	62,052,630.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,253,200.00	11,518,270.00
210502	Хоол, хүнс	35,858,085.00	45,104,320.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,290,370.00	5,430,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,157,400.00	3,475,600.00
210604	Урсгал засвар	13,157,400.00	3,475,600.00
2107	Томилолт, зочны зардал	1,159,300.00	497,100.00
210702	Дотоод албан томилолт	1,159,300.00	497,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,930,640.00	1,465,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,480,640.00	873,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00

**Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	91,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	225,666,955.09	235,462,139.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,231,000.00	4,729,541.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	407,000.00	596,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	220,028,955.09	230,136,198.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,902,773.00	92,011,054.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,638,000.00	75,206,150.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,553,700.00	21,707,360.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	25,659,450.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,491,500.00	27,256,240.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,592,800.00	583,100.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,264,773.00	16,804,904.17
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,264,773.00	16,804,904.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-203,306,476.25	-128,527,696.84
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-203,306,476.25	-128,527,696.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,299,744,450.00	1,417,920,270.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,299,744,450.00	1,417,920,270.00
Улсын төвлөрсөн төсвөөс	1,054,586,900.00	1,041,709,200.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,054,586,900.00	1,041,709,200.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	33,150,950.00	53,209,881.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,150,950.00	53,209,881.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	212,006,600.00	323,001,189.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	212,006,600.00	323,001,189.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,285,389,040.00	1,382,695,270.00
УРСГАЛ ЗАРДАЛ	1,285,389,040.00	1,382,695,270.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,191,080,117.00	1,289,554,525.83
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	783,346,537.00	776,642,125.00
Үндсэн цалин	543,332,195.00	581,395,427.00
Нэмэгдэл	143,131,991.00	142,927,268.00
Урамшуулал	96,882,351.00	52,319,430.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,156,740.00	101,088,199.83
Тэтгэврийн даатгал	67,599,879.00	74,545,900.00
Тэтгэмжийн даатгал	8,003,192.00	6,673,841.83
ҮОМШӨ-ний даатгал	6,298,394.00	5,338,000.00
Ажилгүйдлийн даатгал	1,553,529.00	1,334,500.00
Эрүүл мэндийн даатгал	15,701,746.00	13,195,958.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,006,600.00	322,001,189.00
Гэрэл, цахилгаан	7,997,490.00	8,424,000.00
Түлш, халаалт	195,761,210.00	304,577,189.00
Цэвэр, бохир ус	5,247,900.00	9,000,000.00
Хангамж, бараа материалын зардал	12,614,800.00	13,246,382.00
Бичиг хэрэг	1,142,000.00	1,414,182.00
Тээвэр, шатахуун	5,644,300.00	900,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,795,500.00	2,258,300.00
Ном, хэвлэл	237,500.00	390,600.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,145,000.00	1,240,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,650,500.00	7,043,300.00
Нормативт зардал	54,011,350.00	58,835,330.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,476,300.00	8,989,300.00
Хоол, хүнс	34,742,250.00	47,567,330.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,792,800.00	2,278,700.00
Эд хогшил, урсгал засварын зардал	11,038,700.00	4,052,600.00
Багаж, техник, хэрэгсэл	3,940,000.00	00.00
Тавилга	00.00	708,000.00

**Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Урсгал засвар	7,098,700.00	3,344,600.00
Томилолт, зочны зардал	1,159,300.00	497,100.00
Дотоод албан томилолт	1,159,300.00	497,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,588,400.00	1,315,200.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,138,400.00	575,200.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	19,157,690.00	11,876,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	10,000,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,157,690.00	1,876,400.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,308,923.00	93,140,744.17
Бусад урсгал шилжүүлэг	34,384,700.00	76,335,840.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,300,400.00	22,837,050.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	25,659,450.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,491,500.00	27,256,240.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,592,800.00	583,100.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	25,659,450.00	00.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,264,773.00	16,804,904.17
Төвлөрүүлэх шилжүүлэг	34,264,773.00	16,804,904.17
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,355,410.00	35,225,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,355,410.00	35,225,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,355,410.00	35,225,000.00
Дотоод эх үүсвэрээр	14,355,410.00	35,225,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,355,410.00	35,225,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,355,410.00	-35,225,000.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	763,215,984.63	1,640,459,123.54	3,739,089,545.24	6,142,764,653.41
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	763,215,984.63	1,640,459,123.54	3,739,089,545.24	6,142,764,653.41
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-203,306,476.25	-203,306,476.25
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	763,215,984.63	2,129,263,009.54	3,659,336,274.44	6,551,815,268.61
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	763,215,984.63	2,129,263,009.54	3,659,336,274.44	6,551,815,268.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	763,215,984.63	2,129,263,009.54	3,659,336,274.44	6,551,815,268.61
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-128,527,696.84	-128,527,696.84
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	763,215,984.63	2,129,263,009.54	3,530,808,577.60	6,423,287,571.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,367,785,900.00	1,347,905,484.83	19,880,415.17	98.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,367,785,900.00	1,347,905,484.83	19,880,415.17	98.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,340,715,100.00	1,324,485,334.83	16,229,765.17	98.8

**Бууцаган сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	777,493,400.00	776,642,125.00	851,275.00	99.9
210101	Үндсэн цалин	591,761,600.00	581,395,427.00	10,366,173.00	98.2
210102	Нэмэгдэл	133,378,400.00	142,927,268.00	-9,548,868.00	107.2
210104	Урамшуулал	52,353,400.00	52,319,430.00	33,970.00	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,088,200.00	101,088,199.83	0.17	100.0
210201	Тэтгэврийн даатгал	74,398,200.00	74,545,900.00	-147,700.00	100.2
210202	Тэтгэмжийн даатгал	6,672,500.00	6,673,841.83	-1,341.83	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,338,000.00	5,338,000.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,334,500.00	1,334,500.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	13,345,000.00	13,195,958.00	149,042.00	98.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	325,076,700.00	322,001,189.00	3,075,511.00	99.1
210301	Гэрэл, цахилгаан	8,424,000.00	8,424,000.00	0.00	100.0
210302	Түлш, халаалт	307,652,700.00	304,577,189.00	3,075,511.00	99.0
210303	Цэвэр, бохир ус	9,000,000.00	9,000,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	13,885,200.00	13,885,191.00	9.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,120,000.00	1,119,991.00	9.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	900,000.00	900,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,258,300.00	2,258,300.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	740,600.00	740,600.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,240,000.00	1,240,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,626,300.00	7,626,300.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	71,138,300.00	58,835,330.00	12,302,970.00	82.7
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,989,300.00	8,989,300.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	59,870,300.00	47,567,330.00	12,302,970.00	79.5
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,278,700.00	2,278,700.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,344,600.00	38,344,600.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,344,600.00	3,344,600.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	497,100.00	497,100.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	497,100.00	497,100.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,315,200.00	1,315,200.00	0.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	575,200.00	575,200.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11876400.00	11876400.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,876,400.00	1,876,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27070800.00	23420150.00	3,650,650.00	86.5

**Бууцаган сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	27,070,800.00	23,420,150.00	3,650,650.00	86.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,487,700.00	22,837,050.00	3,650,650.00	86.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	583,100.00	583,100.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,367,785,900.00	1,347,905,484.83	19,880,415.17	98.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,041,709,200.00	1,024,904,295.83	16,804,904.17	98.4
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,041,709,200.00	1,024,904,295.83	16,804,904.17	98.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	326,076,700.00	323,001,189.00	3,075,511.00	99.1
132001	Орон нутгийн төсвөөс	326,076,700.00	323,001,189.00	3,075,511.00	99.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65.00	64.00	1.00	98.5
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	40.00	39.00	1.00	97.5
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00	0.00	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	593.00	593.00	0.00	100.0
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	593.00	593.00	0.00	100.0
630001	Төрийн өмчит ЕБС	593.00	593.00	0.00	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	65.00	65.00	0.00	100.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	46.00	46.00	0.00	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	19.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,491,500.00	53,209,881.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,491,500.00	53,209,881.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		294,191.00
2104	Хангамж, бараа материалын зардал		294,191.00
210401	Бичиг хэрэг		294,191.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,491,500.00	52,915,690.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,491,500.00	52,915,690.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		25,659,450.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,491,500.00	27,256,240.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,481,500.00	53,209,881.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,481,500.00	53,209,881.00
13114	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,481,500.00	53,209,881.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бунчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 1 дүгээр сарын 06 өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг бага ангийн сургалтын менежертэй хавсарган 2021.05.10 хүртэл Д.Уранчимэг 2021.05.10-аас захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Х.Болормаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баярмаа нар зурж байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд бүрийн сурах үйлийг дэмжиж багш бүр сайн багш байх, багшийг үйл ажиллагааны явцад хөгжих боломжийг бүрдүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,539,710.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 23,095.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,166.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 16,613.7 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 6,423,374.6 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 150,543.2 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	125,599.1	131,137.7	5,538.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	11,995.0	2,328.4	(9,666.6)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	113,604.1	128,809.3	15,205.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,448,318.7	6,292,236.8	(156,081.8)
Үндсэн хөрөнгө	7,123,771.4	7,197,825.8	74,054.4
Хуримтлагдсан элэгдэл	(675,452.8)	(905,589.0)	(230,136.2)
Нийт хөрөнгө	6,573,917.8	6,423,374.6	(150,543.2)
Өр төлбөр	22,102.5	87.0	(22,015.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,551,815.3	6,423,287.6	(128,527.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,573,917.8	6,423,374.6	(150,543.2)

Эх сурвалж: Бууцагаан сумын 2021 оны санхүүгийн тайлан

Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Авлагын дансны 2,328.4 мянган төгрөг болж 9,666.6 мянган төгрөгөөр буурсан нь 9,985.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэцийг хүлээн авсантай холбоотой байна. Мөн авлагын үлдэгдэлд эзэн холбогдогч нь нас барсан 1,960.0 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 128,809.3 мянган төгрөг болж 15,205.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 1,734.4 мянга, эм боох материал 51.6 мянга, бэлэн бүтээгдэхүүн 1,129.7 мянга, бичиг хэргийн материал 343.9 мянга, аж ахуйн материал 708.0 мянга, хүнсний материал 2,550.0 мянга, бусад хангамжийн материалын үлдэгдэл 8,687.7 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна. Энэ нь тусгай зориулалтын материалд 1,734.4 мянган төгрөгийн сурах бичиг орлого авсан, бусад хангамжийн материалын дансанд БСШУЯ-ны сайдын багцаас 3,878.2 мянган төгрөгийн дотуур байрны хүүхэд хөгжлийн төвд сургалтын хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,197,825.8 мянган төгрөг болж 74,054.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 35,225.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 860.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хандиваар авсантай холбоотой байна.

Тайлант онд 35,225.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан нь БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 26,125.9 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, ном, Бууцагаан сумын ЗДТГ-аас 1,958.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, урд онд мөнгийг шилжүүлж авлага үүсгэсэн 9,885.0 мянган төгрөгийн дэлгэцийг орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,423,287.6 мянган төгрөг болж 128,527.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 128,527.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,786,866.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,786,866.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 550,384.3 мянган төгрөгөөр бууруулан 1,236,482.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсөвт 5 удаа өөрчлөлт оруулан 131,303.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн цалин, НДШ, эд хогшил, урсгал засварын зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,367,785.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,041,709.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 326,076.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 1,041,709.2 мянга, орон нутгийн төсвөөс 323,001.2 мянга, урсгал үйл ажиллагаанд 1,347,905.5 мянган төгрөгийг зарцуулж тусгай зориулалтын шилжүүлгээс 16,804.9 мянган төгрөгийг улсын

төсөвт төвлөрүүлсэн, харин орон нутгийн төсвөөс гүйцэтгэлээр санхүүжүүлж 3,075.5 мянган төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,347,905.5 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 851.3 мянга, байр ашиглалттай холбоотой зардлаас 3,075.5 мянга, хоолны зардлаас 12,302.9 мянга, үдийн цайны зардлаас 3,650.6 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 53,209.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулсан байна. Энэ нь дээд шатны төсөв захирагчаас 25,659.5 мянган төгрөгийг 2 үйлчилгээний ажиллагсад тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 27,256.2 мянган төгрөгийг 6 багшид хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх тэтгэмж, БСУГ-аас сурагчдын түвшин тогтоох шалгалтын бичиг хэргийн зардалд 294.2 мянга нийт 53,209.9 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Н.Бүнчинсүрэн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 3 зорилтын хүрээнд 65 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 875,427.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 183,953.3 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь, байр ашиглалттай холбоотой зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

**Бууцаган сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,866,091.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас иж бүрэн мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна. Харин тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт 9 сар, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ 12 сар, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) 1 сар, 5 сар, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 1 сар, 3 сар, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн

гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 6,7,12 сарын мэдээллүүдийг дахин орж зассанаас хоцорсон төлөвтэй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Мэдээлвэл зохих/удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	0	2
2	Хагас жил	4	4	4	0	
3	Улирал бүр	1	4	4	0	
4	Сар бүр	3	36	36	0	
5	Тухай бүр	8	96	87	9	
	Нийт	27	151	140	9	2

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд нийт 1,367,785.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 1,347,905.5 төгрөгийг зарцуулж оны эцэст 19,880.4 мянган төгрөг буюу төсвийн 2.5 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Мөн үдийн цайны зардал нь оны эхэнд 41,987.7 мянган төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны 96,570.3 мянган төгрөг анх батлагдсан ба Санхүү Төрийн сангийн хэлтэст бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт өгч аймгийн Засаг даргын "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/289, А/742 дугаар захирамжуудаар үдийн цайны зардлаас 15,500.0 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас 36,700.0 мянган төгрөгөөр бууруулж цалин, НДШ, эд хогшил худалдан авах, гамшгийн эрсдэлийн сан зэрэг зардлуудад тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 325,076.7 мянган төгрөгөөр, тодотголоор 2,248.7 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 322,828.0 мянган төгрөгийг зарцуулсан ба урд оны халаалтын өглөгт 22,078.5 мянган төгрөгийн өглөгийг шилжүүлсэн байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан ба нийт 165,007.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 154,969.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 153.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 9,885.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн биелэлтийг Бууцагаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021.06.11-ны өдрийн 33 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 40,822.4 мянган төгрөгийн зөрчил илэрч 3,607.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,960.0 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

1.Тогооч Н.Ганхөлөгийн амралтын цалинд 975.1 мянган төгрөг бодогдож 950.0 мянган төгрөгийг урьдчилж олгосон ба 155.3 мянган дутуу суутгаж санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтууд Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Тогооч Н.Ганхөлөгөөр 155.3 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 45,104.3 мянган төгрөгийн хоолны зардал гарч 11973 хүүхэд өдөр хамрагдаж 1 хүүхдэд ногдох нормативд зардал 1452 төгрөг буюу 3,452.1 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын “Хүүхдийн хоолны дундаж норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолын 1-т “Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 (хоёр мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай” гэсэн заалтууд Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хүүхдийн хоолны нормативд зардлыг хэтрүүлэн зарцуулсан 3,452.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлант онд 1,367,785.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 1,347,905.5 төгрөгийг зарцуулж оны эцэст 19,880.4 мянган төгрөг буюу төсвийн 2.5 хувийг буцаан төвлөрүүлсэн, мөн хэмнэгдсэн зардлаас гүйлгэн зарцуулж 35,255.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8¹ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид дотуур байрны хүүхдийн хоол, Үдийн цай хөтөлбөрийн нормативд зардлыг гүйлгэн зарцуулдаг явдлыг таслан зогсоож засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах

2. Тухайн байгууллага нь 2021 оны эцэст 2,328.4 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа бөгөөд үүний 1,960.0 мянган төгрөг нь эзэн холбогдогч нь нас барсан он удаан жил болсон авлага байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн "Үнэн зөв байх", санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Үнэн зөв байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах арга хэмжээг авч цаашид өглөг, авлага үүсгэхгүй байх

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бууцагаан сумын ЕБС	4	40822.4	0	0	2	3,607.4	0	0	2	37,215.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____